**МОНГОЛ УЛС**
**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 10 өдөр Дугаар А/253 Алтай хот

Сумдын баяр наадмын хугацааг
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Үндэсний Их баяр наадам, Тулгар Төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ой, Дэлгэр, Эрдэнэ, Чандмань, Цогт, Цээл, Халиун, Бигэр, Алтай, Бугат сумдын баяр наадмыг 07 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд, Шарга, Төгрөг, Тонхил, Дарив, Хөхморьт Баян-Уул, Жаргалан, Тайшир сумдын баяр наадмыг 07 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Баяр наадмын арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж, цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан, ёслол хүндэтгэлийн өндөр хэмжээнд, хуулийн дагуу зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Г.Ууганбаатар)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

C:/My Documents/ZAHNR-3A-4doc
0201000791